



Шагдаржав овогтой Даваадорж миний бие 1982 оны 10-р сарын 25-ны өдөр Завхан аймгийн Сонгино сумын Д.Шагдаржавын 2-р хүү болон мэндэлсэн. Ам бүл 4. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. Бага насаа эцэг эхийн гар дээр өнгөрөөж 1990 онд

Сонгино сумын 10-н жилийн дунд сургуулийн 1-р ангид элсэн орж улмаар 1998 онд төгсөөд бүрэн дунд боловсрол эзэмшсэн.

Мэргэжил: 2000 онд Улаанбаатар хот дахь Орхон Их сургуульд элсэн орж 2005 онд Хууль эрх зүйн чиглэлээр бакалаврийн зэрэгтэй төгссөн.

Ажил эрхлэлт: 2005 онд Улаанбаатар хотод “IVANHOE MINES” гадаадын хөрөнгө оруулагчтай компаньд туслах няраваар 2006-2007 онд “Номин холдинг” “Эрдэнэт хивс” компанид борлуулагчаар тус тус ажиллаж байсан.

2009-2011 он хүртэл Сонгино сумын ЗДТГазар Иргэний бүртгэлийн ажилтанаар ажиллаж байгаад 2011 оны 11-р сарын 23-наас тасралтгүй Сонгино сумын Улсын бүргэгчээр одоог хүртэл ажиллаж байна.